

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/156/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Ч.Сугардорж Утас: 7036-2442 Цахим хаяг: sugardorjch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ГСЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ
СУМЫН РАШААНТ ТОСГОНЫ ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.МАРАЛ-ЭРДЭНЭ ТАНАА

2026.02.05 № СЭА-2026/156/НА-СТА-ТЗШ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Аймгийн ЭМГ-аас хийсэн хяналт шалгалтаар зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага тооцолгүй, эмийн эргэлтийн сангийн эмийн зардлаас төлбөрийг барагдуулж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан,
- Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **500.0 мянган** төгрөгийн цалингийн авлага, **4,579.0 мянган** төгрөгийн ХХОАТ-ын өглөг тус тус өглөг үүсгэсэн,

- Эмийн сангийн борлуулалтын орлогын **7,935.3 мянган** төгрөгийг тухай бүр бус 6-13 өдрийн дараа төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлсэн,
- Цалин, урамшууллын зардлаас **466.5 мянган** төгрөгийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд холбогдох дээд байгууллагын зөвшөөрөлгүй зориулалт бусаар гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс ЭМДС-аас нэхэмжилсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь эх олонлогийн, системийн, эмч, байцаагчийн гэсэн 4 төрлөөр санхүүжилт хасагдсан зөрчлийг давтан гаргасан.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6.10-д “Төсвийн байгууллага нь мөнгөн касстаа бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана”, 3.6.11-д “Төсвийн байгууллагын кассын үйл ажиллагаатай холбоотой хяналтыг тухайн байгууллага тогтмол зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бүртгэлийг хөтөлнө, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” -ыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төвийн барилгын сангийн засварын ажлыг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 154,466.9 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийлгэж бүрэн ашиглалтад орсныг үндсэн хөрөнгийн орлогод авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орхонтуул сумын Рашаант тосгоны ЭМТ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн

бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байгаа бөгөөд уг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Орхонтуул сумын Рашаант тосгоны ЭМТ нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.6 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	193,885,816.67	239,298,051.98
2	31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	32,420,504.81	51,438,336.68
3	31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	32,420,504.81	51,438,336.68
4	31210	Төгрөг	32,420,504.81	51,438,336.68
5	31211	Төрийн сангийн харилцах	32,420,504.81	51,438,336.68
6	33	АВЛАГА	138,060,716.63	143,482,593.10
7	33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	311,908.12	500,000.00
8	33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	115,465,955.93	139,675,100.13
9	33300	Татаас, санхүүжилтийн авлага		2,907,792.00
10	33500	Бусад авлага	22,282,852.58	399,700.97
11	33510	Байгууллагаас авах авлага	1,640,848.00	-
12	33520	Хувь хүмүүсээс авах авлага	20,642,004.58	399,700.97
13	35	БАРАА МАТЕРИАЛ	23,404,595.23	44,377,122.20
14	35100	Түүхий эд материал	21,424,945.23	37,897,472.20
15	35110	Тусгай зориулалттай материал	14,637,327.12	24,596,467.43
16	35130	Эм боох материал	6,787,618.11	13,301,004.77
17	35400	Хангамжийн материал	1,979,650.00	6,479,650.00
18	35420	Аж ахуйн материал	1,895,150.00	6,395,150.00
19	35470	Бусад хангамжийн материал	84,500.00	84,500.00
20	2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	316,428,067.01	436,730,982.48
21	39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	316,428,067.01	436,730,982.48
22	39200	Биет хөрөнгө	310,364,067.01	430,666,982.48
23	39201	Барилга, байгууламж, орон сууц	259,780,135.00	414,247,035.00
24	39202	Хуримтлагдсан элэгдэл	(53,504,604.72)	(63,663,333.88)
25	39203	Авто-тээврийн хэрэгсэл	51,000,000.00	51,000,000.00
26	39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,971,811.62)	(27,071,811.62)
27	39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	133,473,272.73	147,372,372.73
28	39206	Хуримтлагдсан элэгдэл	(73,679,303.63)	(102,987,200.04)
29	39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,501,640.49	26,501,640.49
30	39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,235,261.24)	(14,731,720.20)
31	39300	Биет бус хөрөнгө	6,064,000.00	6,064,000.00
32	39303	Бусад биет бус хөрөнгө	6,064,000.00	6,064,000.00
33	3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	510,313,883.68	676,029,034.46
34	4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,439,800.00	4,036,461.00

35	41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,439,800.00	4,036,461.00
36	41300	Өглөг	7,439,800.00	4,036,461.00
37	41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	4,036,461.00
38	41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,439,800.00	-
39	5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	502,874,083.68	671,992,573.46
40	51	Засгийн газрын хувь оролцоо	502,874,083.68	671,992,573.46
41	51100	Засгийн газрын оруулсан капитал	234,269,565.66	234,269,565.66
42	511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	234,269,565.66	234,269,565.66
43	51200	Хуримтлагдсан үр дүн	103,958,218.02	273,076,707.80
44	51210	Өмнөх үеийн үр дүн	6,402,278.81	103,958,218.02
45	51220	Тайлант үеийн үр дүн	97,555,939.21	169,118,489.78
46	51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	164,646,300.00	164,646,300.00
47	6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	510,313,883.68	676,029,034.46

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	851,892,503.04	1,154,365,110.99
2	12	БУС ОРЛОГО	124,755,393.80	1,154,365,110.99
3	120	Нийтлэг татварын бус орлого	124,755,393.80	269,944,726.77
4	120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,102,039.00	103,354,617.77
5	1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,102,039.00	103,354,617.77
6	120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	44,667,035.00	166,166,000.00
7	120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	986,319.80	424,109.00
8	122	Тусламжийн орлого	-	884,420,384.20
9	1221	Хандив тусламж /дотоод/	-	884,420,384.20
10	122111	Урсгал санхүүжилтийн орлого\	36,357,563.09	30,999,498.12
11	122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	853,420,886.10
12	13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	727,137,109.24	-
13	1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	727,137,109.24	-
14	134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	727,137,109.24	-
15	II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	789,214,126.92	986,726,621.21
16	21	УРСГАЛ ЗАРДАЛ	789,214,126.92	986,726,621.21
17	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	789,214,126.92	986,726,621.21
18	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	499,357,107.00	621,932,223.00

19	210101	Үндсэн цалин	315,709,454.00	345,357,547.00
20	210102	Нэмэгдэл	158,397,453.00	225,619,578.00
21	210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	15,440,000.00
22	210104	Урамшуулал	25,250,200.00	35,515,098.00
23	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,650,160.03	79,354,665.91
24	210201	Тэтгэврийн даатгалын зардал	43,534,594.49	54,605,382.71
25	210202	Тэтгэмжийн даатгалын зардал	4,960,597.57	6,016,441.62
26	210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,650,729.36	3,557,288.34
27	210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,432,399.03	2,756,318.98
28	210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	10,071,839.58	12,419,234.26
29	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,657,563.09	30,999,498.12
30	210301	Гэрэл, цахилгаан	4,216,363.09	8,527,098.12
31	210302	Түлш, халаалт	26,919,000.00	19,950,000.00
32	210303	Цэвэр, бохир ус	2,522,200.00	2,522,400.00
33	2104	Хангамж, бараа материалын зардал	14,083,480.90	19,444,715.00
34	210401	Бичиг хэрэг	1,440,500.00	3,671,884.00
35	210402	Тээвэр, шатахуун	11,097,980.90	10,108,699.00
36	210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,000.00	2,310,232.00
37	210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	3,193,900.00
38	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	895,000.00	160,000.00
39	2105	Нормативт зардал	101,812,937.93	151,136,220.53
40	210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	94,973,098.93	143,227,445.53
41	210502	Хоол, хүнс	5,089,839.00	7,108,775.00
42	210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,750,000.00	800,000.00
43	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,380,500.00	6,880,000.00
44	210601	Багаж, техник, хэрэгсэл	380,500.00	790,000.00
45	210604	Урсгал засвар	3,700,000.00	6,090,000.00
46	2107	Томилолт, зочны зардал	3,168,980.00	1,608,000.00
47	210702	Дотоод албан томилолт	3,168,980.00	1,608,000.00
48	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,564,047.00	24,429,714.12
49	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,114,047.00	24,429,714.12
50	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	-
51	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,319,350.97	49,461,584.53
52	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,706,260.00	1,398,500.00
53	210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,613,090.97	48,063,084.53
54	III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	97,555,939.21	169,118,489.78
55	VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	97,555,939.21	169,118,489.78

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	699,110,855.31	951,541,719.28
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,735,785.00	951,541,719.28
3	120	Нийтлэг татварын бус орлого	77,735,785.00	122,329,977.38
4	120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	77,735,785.00	122,329,977.38
5	1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	77,735,785.00	122,329,977.38
6	122	Тусламжийн орлого	-	860,211,240.00
7	122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	-	829,211,741.90
8	122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	30,999,498.12
9	13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	621,375,070.31	-
10	1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	621,375,070.31	-
11	134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	621,375,070.31	-
12	II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	734,903,923.39	961,323,385.52
13	21	УРСГАЛ ЗАРДАЛ	734,903,923.39	961,323,385.52
14	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	734,903,923.39	961,323,385.52
15	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	499,357,107.00	617,853,215.00
16	210101	Үндсэн цалин	315,709,454.00	343,768,923.00
17	210102	Нэмэгдэл	158,397,453.00	223,129,194.00
18	210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	15,440,000.00
19	210104	Урамшуулал	25,250,200.00	35,515,098.00
20	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,358,040.03	78,888,137.91
21	210201	Тэтгэврийн даатгалын зардал	43,814,558.74	54,138,857.71
22	210202	Тэтгэмжийн даатгалын зардал	5,062,712.19	6,016,438.62
23	210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,746,028.65	3,329,917.62
24	210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,452,234.32	2,983,689.70
25	210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	10,282,506.13	12,419,234.26
26	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,657,563.09	30,999,498.12
27	210301	Гэрэл, цахилгаан	4,216,363.09	8,527,098.12
28	210302	Түлш, халаалт	26,919,000.00	19,950,000.00
29	210303	Цэвэр, бохир ус	2,522,200.00	2,522,400.00
30	210401	Бичиг хэрэг	1,440,500.00	2,556,700.00
31	210402	Тээвэр, шатахуун	11,097,980.90	10,108,699.00
32	210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,000.00	2,491,232.00
33	210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	3,183,210.00
34	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	895,000.00	297,700.00
35	2105	Нормативт зардал	90,699,340.40	176,181,612.50
36	210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	83,859,501.40	167,016,347.50
37	210502	Хоол, хүнс	5,089,839.00	6,865,265.00
38	210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,750,000.00	2,300,000.00
39	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,380,500.00	8,690,000.00
40	210601	Багаж, техник, хэрэгсэл	380,500.00	2,200,000.00
41	210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	400,000.00
42	210604	Урсгал засвар	3,700,000.00	6,090,000.00
43	2107	Томиллолт, зочны зардал	3,168,980.00	1,608,000.00
44	210702	Дотоод албан томиллолт	3,168,980.00	1,608,000.00
45	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,792,652.00	27,246,881.00
46	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,342,652.00	27,246,881.00
47	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	-

48	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,706,260.00	1,218,500.00
49	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,706,260.00	1,218,500.00
50	III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	564,494.98	21,217,831.87
51	V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	19,329,700.00	2,200,000.00
52	22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,329,700.00	2,200,000.00
53	2200	Дотоод эх үүсвэрээр	19,329,700.00	2,200,000.00
54	225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,329,700.00	2,200,000.00
55	VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(19,329,700.00)	(2,200,000.00)
56	VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(18,765,205.02)	19,017,831.87
57	101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	51,185,709.83	32,420,504.81
58	20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,420,504.81	51,438,336.68

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	234,269,565.66	164,646,300.00	6,402,278.81	405,318,144.47
2	3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	234,269,565.66	164,646,300.00	6,402,278.81	405,318,144.47
3	9	Тайлант үеийн үр дүн	-	-	97,555,939.21	97,555,939.21
4	10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	234,269,565.66	164,646,300.00	103,958,218.02	502,874,083.68
5	11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	234,269,565.66	164,646,300.00	103,958,218.02	502,874,083.68
6	13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	234,269,565.66	164,646,300.00	103,958,218.02	502,874,083.68
7	19	Тайлант үеийн үр дүн	-	-	169,118,489.78	169,118,489.78
8	20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	234,269,565.66	164,646,300.00	273,076,707.80	671,992,573.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,251,751,200.00	951,541,719.28
2	12	Татварын бус орлого	1,251,751,200.00	951,541,719.28
3	120	Нийтлэг татварын бус орлого	167,705,100.00	122,329,977.38
4	120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	167,705,100.00	122,329,977.38
5	122	Тусламжийн орлого	1,084,046,100.00	829,211,741.90
6	122001	Хандив тусламж /дотоод/	1,084,046,100.00	829,211,741.90
7	II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,284,171,500.00	932,523,887.41
8	21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,284,171,500.00	932,523,887.41
9	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,284,171,500.00	932,523,887.41
10	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	807,289,100.00	617,853,215.00
11	210101	Үндсэн цалин	447,395,700.00	343,768,923.00
12	210102	Нэмэгдэл	277,927,000.00	223,129,194.00
13	210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,300,000.00	15,440,000.00
14	210104	Урамшуулал	48,666,400.00	35,515,098.00
15	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,697,900.00	78,888,137.91
16	210201	Тэтгэврийн даатгал	67,928,900.00	54,138,857.71
17	210202	Тэтгэмжийн даатгал	8,192,300.00	6,016,438.62
18	210203	ҮОМШӨ-ний даатгал	4,096,100.00	3,329,917.62
19	210204	Ажилгүйдлийн даатгал	4,096,100.00	2,983,689.70
20	210205	Эрүүл мэндийн даатгал	16,384,500.00	12,419,234.26
21	2104	Хангамж, бараа материалын зардал	37,373,700.00	18,637,541.00
22	210401	Бичиг хэрэг	2,900,000.00	2,556,700.00
23	210402	Тээвэр, шатахуун	23,000,000.00	10,108,699.00
24	210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,249,900.00	2,491,232.00
25	210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,023,800.00	3,183,210.00
26	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	297,700.00
27	2105	Нормативт зардал	282,723,700.00	176,181,612.50
28	210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	265,764,100.00	167,016,347.50
29	210502	Хоол, хүнс	14,500,000.00	6,865,265.00
30	210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,459,600.00	2,300,000.00
31	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,000,000.00	10,890,000.00
32	210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	4,400,000.00
33	210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	400,000.00
34	210604	Урсгал засвар	6,000,000.00	6,090,000.00
35	2107	Томилолт, зочны зардал	8,000,000.00	1,608,000.00
36	210702	Дотоод албан томилолт	8,000,000.00	1,608,000.00
37	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,750,000.00	27,246,881.00
38	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,750,000.00	27,246,881.00
39	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,337,100.00	1,218,500.00
40	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,337,100.00	1,218,500.00
41	8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(32,420,300.00)	19,017,831.87
42	9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32,420,300.00	(19,017,831.87)
43	7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	32,420,300.00	(19,017,831.87)
44	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	32,420,504.81

45	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	51,438,336.68
46	6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	33	0
47	61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	0
48	610001	Төсвийн байгууллага	1	0
49	62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	16	0
50	620001	Удирдах ажилтан	1	0
51	620002	Гүйцэтгэх ажилтан	12	0
52	620003	Үйлчлэх ажилтан	3	0
53	65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	16	0
54	650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	12	0
55	650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 70,007.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 13,480.8 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага, 56,526.2 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

*Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 13,480.8 мянган төгрөгийн залруулагдаагүй материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,588.7 мянган төгрөгөөр их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.*

3.1 Албан шаардлага

1. Аймгийн ЭМГ-аас хийсэн хяналт шалгалтаар мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлага, устгалын бүртгэл дутуу, эмнэлгийн гаралтай хог хаягдлыг зөв ангилж, ялгаж, цуглуулах, устгах заавар, журмыг мөрдөөгүй зэрэг зөрчлүүд илэрч 6,000.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан байна. Зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцолгүй, эмийн эргэлтийн сангийн эмийн зардлаас төлбөрийг барагдуулж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.1.2-т “*Үр дүнгийн ба хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, зөрчсөн ажилтанд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх*”, 7.4-т “*Албан хаагчийн үүрэг*”, 7.4.2 дэх “*Ажлын байрны тодорхойлолт*”- д заасан болон үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж, ...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцож, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

- Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 500.0 мянган төгрөгийн цалингийн авлага, 4,579.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг тус тус үүсгэсэн,
- Эмийн сангийн борлуулалтын орлогын 7,935.3 мянган төгрөгийг тухай бүр бус 6-13 өдрийн дараа төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлсэн.

Эдгээр зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь “*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:*” 20.2.5 дахь “*... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дугаар тогтоолоор батлагдсан “*Төрийн сангийн үйл ажиллагааны журам*”-ын 3 дугаар зүйлийн 3.6.10-д “*Төсвийн байгууллага нь мөнгөн касстаа бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд ажлын дараагийн*

өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана”, 3.6.11-д “Төсвийн байгууллагын кассын үйл ажиллагаатай холбоотой хяналтыг тухайн байгууллага тогтмол зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бүртгэлийг хөтөлнө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу нягтлан бодогч Г.Баттуул, эмийн санч Г.Заяа нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3. Цалин хөлс, нэмэгдэл урамшлын батлагдсан төсвөөс ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 466.5 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

4. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс ЭМДС-аас нэхэмжилсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь эх олонлогийн, системийн, эмч, байцаагчийн гэсэн 4 төрлөөр хасагдсан зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “*Чанар, төлбөрийн хяналтын журам*”-ын шалгуурыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана*”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хашаа, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүхий 33 нэр төрлийн 56,526.2 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох болон актлах саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь *“илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”* гэсэн заалттай нийцэхгүй, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д *“... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй...”* гэсэн заалтууд болон болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж байгаа хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон актлах эсэх саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1. Хариуцлага тооцох албан шаардлага.	1	0			1	0						
Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан.	1	13,014.3			1	13,014.3						

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	466.5			1	466.5					
Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан.	1	0			1	0					
Үлдэх өртөг "0" болсон 33 нэр төрлийн үндсэн хөрөнгийг дахин үнэлээгүй.	1	56,526.2					1	56,526.2			
Дүн	5	70,007.0			4	13,480.8	1	56,526.2			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								